

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН  
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

*2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр*

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин /Тоо хэмжээ, хувь/	Хүрсэн түвшин /Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр /мян.төг/	Тайлбар
Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоодын сургалтын тоо	5-аас дээш	100 хувь /14 удаагийн сургалт/	100 хувь 84 албан хаагч сертификат, 6 албан хаагч үнэмлэх авсан	Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, “Нийслэлийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны төв болон бусад нийслэлийн холбогдох байгууллагаас зохион байгуулсан 74 удаагийн сургалтад хамрагдав. Байгууллагын Ёс зүйн зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 3135000 төгрөгийг зарцуулав. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах батлах, хэрэгжилтийг хангах журам”, 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ыг хэрэгжүүлэх аргачлал, загварыг танилцуулсан 4 МОДУЛЬ ЦАХИМ ХИЧЭЭЛ-ийг <a href="http://surqalt.unelgee.gov.mn">http://surqalt.unelgee.gov.mn</a> холбоосоор цахим сургалтад 84 албан хаагч хамрагдаж, “Үр дүнд суурилсан

							<p>бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэрчилгээ авав.</p> <p>Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн бакалаврын оройн ангийг эрх зүйч мэргэжлээр 1 албан хаагч дүүргэж, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 1 албан хаагч, Монголын Хуульчдын холбооны дэргэдэх Хуульчийн үргэлжилсэн сургалтад 1 албан хаагч, Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтийн Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт үнэлгээ “Алсын хараа – 2050” сургалтад 8 албан хаагч тус тус хамрагдаж бакалаврын диплом, үнэмлэх гардан авав. (1 бакалаврын диплом, 6 үнэмлэх).</p>
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	100 хувь /313 албан хаагч	Давхардсан тоогоор 777 албан хаагч	Нийт 76 удаагийн сургалтад (цахимаар 58, танхимын 18) нийт давхардсан тоогоор 777 албан хаагч хамрагдав.
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	5 албан хаагч	7 албан хаагч	<p>Бүгд найрамдах Турк Улсын төрийн албаны болон бусад байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох сургалт, семинарт оролцох, “КАТ1Р” хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй тавигдах шаардлагыг хангасан 4 албан хаагчийн нэрийг дэвшүүлсэн.</p> <p>ОУ-ын бетоны нийгэмлэгийн зохион байгуулсан “1st JSCE Concrete Committee” хагас өдрийн цахим сургалт, Япон улсын Хиросимо Их Сургуулийн профессор /H.Miura/-ийн “Барилгыг газар хөдлөлтийн үйлчлэлд төсөөлөхөд ашиглах хөрсний өгөгдөл хэлбэлзлийг байгуулах” сэдэвт сургалт, БНХАУ-ын Элчин сайдын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсээс хамтран зохион байгуулсан “Дэд бүтэц ба барилга”, “Хөгжиж байгаа орнууд ба цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт” сургалтад цахимаар 7 албан</p>

							хаагч хамрагдав. "Өндөр барилгын бүтээц төлөвлөлт Япон улсын туршлага", "Улаанбаатар хотын барилга байгууламжийн эрсдэлийн үнэлгээ" зэрэг сэдвүүдээр Япон улсын эрдэмтэн Sei'ichiro Fukushima RKK Consulting, доктор (Ph.D)-ын лекцэд 1 албан хаагч хамрагдав.
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөц бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	100 хувь /94 албан хаагч	100 хувь	Нийт 87 албан хаагчаас төрийн захиргааны 76 албан хаагч, төрийн үйлчилгээний 11 албан хаагч байна. Үүнээс төрийн захиргааны 76 албан хаагчийн 33 архитектор, 23 инженер, 8 газар зохион байгуулагч, эдийн засагч, хуульч, эрх зүйч зэрэг 12 албан хаагч. Зөвлөх архитектор 4, зөвлөх инженер 4, мэргэшсэн архитектор 10, мэргэшсэн инженер 14, мэргэшсэн эдийн засагч 2, мэргэшсэн хуульч 1, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин 1 тус тус байна. Барилга, архитектур, инженерийн мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 74% (газрын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн ажилтнуудаар бүрэн хангагдсан) 5-аас дээш жил ажилласан ажилтны эзлэх хувь 76% (дадлага, туршлагатай болон шинэ залуу ажилтны зохистой хослол бүрдсэн) Төрийн захиргааны 54 албан хаагч зэрэг дэвтэй байна. Доктор 1, Магистр 28, бакалавр 58.
Хэсгийн дундаж 100 хувь							
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэл ээр	34 албан хаагч шагнал, 106 албан хаагч урамшуулал	Шагнал 69 албан хаагч, 255 албан хаагч үр дүнгийн урамшуулал /давхардсан тоогоор/	Төрийн албаны тухай хууль, "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Газрын Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу давхардсан тоогоор 255 албан хаагчид 148,046.014 төгрөгийн мөнгөн урамшуулал, 22 албан хаагчид шагналын дагалдах 3.200,000 төгрөгийн мөнгөн урамшуулал, 14 албан

							<p>хаагчид 3.900,000 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгов.</p> <p>Нийслэлээс Онцгой комиссын шуурхай штабын Орон зайн дүн шинжилгээний багт ажиллаж байгаа 2 албан хаагчид 2, 3, 4, 5 дугаар сарын илүү цагийн нэмэгдэл, цалинг зохих журмын дагуу олгов.</p> <p>2021 оны Сар шинийн баяр, Газрын харилцааны ажилтны өдөр, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Улсын их баяр наадам, Барилгын салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын ажилд дорвитой хувь нэмэр оруулж, хот байгуулалт, газрын харилцааны салбарт тогтвор суурьшилтай, идэвх санаачилгатай амжилт гарган ажилласан албан хаагчдыг зохих журмын дагуу шагналд 84 албан хаагчийг нэр дэвшүүлж тодорхойлноос 16 нэр төрлийн шагналаар 69 албан хаагчийг шагнуулав.</p>
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв шатлал ахиулах	Гүйцэтгэл ээр	106 албан хаагч	Давхардсан тоогоор 150 албан хаагч	<p>Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сүүлийн гурван жил дараалан "А" үнэлэгдсэн 24 албан хаагчид цалингийн шатлалыг алгасуулан, 4 албан хаагчийг ажилласан жилээр тус тус нэмэгдүүлж, бусад төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, ур чадварын нэмэгдлийг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу нэмэгдүүлж Газрын даргын 2021 оны Б/05 дугаар тушаалаар 87 албан хаагчийн цалинг шинэчлэн батлуулав.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/270 дугаар захирамжийг үндэслэн 40 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоов.</p>
	4	Албан хаагчдын ажлын	Ажлын байрны таатай орчны	Сэтгэл ханамж 80 хувиас	80 хувь	—	Газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар байгуулсан Газраас үзүүлж буй ажил, үйлчилгээний гүйцэтгэл,

		байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	сэтгэл ханамжийн санал асуулга	дээш			түвшний талаарх сэтгэл ханамжийн байдлыг судлах судалгааны багаас цаасан суурьтай судалгаа болон "google ашиглан цахим судалгааг 25 иргэн, хуулийн этгээдээс авсан. Судалгааны багаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд нэмэлт материал авах, буцаах үндэслэлийг сайтар тайлбарлах, нэгдсэн төвийн үйлчилгээний ажилтнуудыг мэдээллээр тогтмол хангаж ажиллах зэрэг зөвлөмжийг гарган ажиллав.
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэл ээр	1 албан хаагчид сард олгох хоолны мөнгө 5000 төгрөг, Унааны зардал 11000 төгрөг	87 албан хаагч	Нийслэлээс баталсан төсвийн хүрээнд нэг албан хаагчид өдрийн хоолны мөнгө 4500 төгрөг, унааны зардал сард 11000 төгрөгийг тус тус олгож байна.
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	108 албан хаагч	12.900.0	Газрын даргын 2021 оны Б/58 дугаар тушаалаар газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд 86 албан хаагчийг хамруулж, Сөүл эмнэлэгтэй гэрээ байгуулав. Нэг хүний 150000 төгрөг, нийт 12.900,000 төгрөгийг шийдвэрлүүлэв. Эмнэлгийн үзлэг шинжилгээнд 86 албан хаагч хамрагдав.
			Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100 хувь	86 албан хаагч 100%	

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ч.БАДАМХАНД

Т.БУЯНЖАРГАЛ